



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 251

Улаанбаатар хот

“Мэдээлэл холбооны сүлжээ”
хязгаарлагдмал хариуцлагатай компанийн
2020 оны үйл ажиллагаа, эдийн засгийн
үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон
контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Мэдээлэл холбооны сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон гүйцэтгэх захирал Ч.Золбаяртай байгуулсан контрактын биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“Мэдээлэл холбооны сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяртай байгуулах контрактыг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу 1 жилийн хугацаатай шинэчлэн байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

2021.06.24
БААТРАЖАВ

132001208

ТӨБЗГ тогтоол-/2021